



**ЭМЭЭЛТИЙН ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 01 сарын 12 өдөр

Дугаар А/08

Улаанбаатар хот

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Төрийн орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2015 оны “Нийслэлийн 2016 оны төсөв батлах тухай” 32/33 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын 2016 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн А/21 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн 2016 оны төсвийн хөрөнгөөр хийгдэх “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл /Холбоо хангамж, цахилгаан хангамж, дулаан хангамж, технологийн уурын шугам, усан хангамж, ариутгах татуурга, хонгилын систем/”-ийн зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга	Багануур дүүргийн худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн	О.Мөнхгал
Гишүүд	Мэдээллийн технологийн инженер	Г.Цэнджав
	Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	Т.Түвшинзаяа
	Иргэний төлөөлөл	Л.Мөнхтуяа
Нарийн бичгийн дарга	Архитектор	Э.Төмөртогтох

2. Техникийн тодорхойлолт бэлтгэх, тендерийн урилга, баримт бичгийг боловсруулах, тендер хүлээн авах, нээх ажиллагааг хуулийн дагуу гүйцэтгэх, гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг захиалагчид өгч ажиллахыг Үнэлгээний хорооны дарга О.Мөнхгалд даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төсөл хэрэгжүүлэх хэлтсийн ерөнхий инженер бөгөөд барилгын инженер Г.Пүрэвдоржид даалгасугай.

ДАРГА



М.ГОНЧИГЖАВ

**3150600018**